



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

"Өөртөө хайртай 72 цаг" эрүүл мэнд,
сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн, нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.4, 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулж буй "Өөртөө хайртай 72 цаг" нөхөн сэргээх эмчилгээнд дүүргийн Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсгийн албан хаагчдыг хамруулж, эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлсүгэй.

2."Өөртөө хайртай 72 цаг" нөхөн сэргээх эмчилгээнд хамрагдах албан хаагчдын нэрсийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Эмчилгээнд шаардагдах 2,400,000 (Хоёр сая дөрвөн зуу мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


4.Нөхөн сэргээх эмчилгээнд албан хаагчдыг бүрэн хамруулж, санхүүгийн тайлан, холбогдох баримтыг эмчилгээнд хамрагдсанаас хойш ажлын 5 өдөрт Засаг даргын Тамгын газрын санхүүд ирүүлэхийг Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг (цагдаагийн дэд хурандаа Д.Билгээ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 09 сарын 11-ны өдрийн 1168 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



**“ӨӨРТӨӨ ХАЙРТАЙ 72 ЦАГ” НӨХӨН СЭРГЭЭХ
ЭМЧИЛГЭЭНД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ**

Д/д	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүр зардал	Нийт зардал
1.	“Өөртөө хайртай 72 цаг” нөхөн сэргээх эмчилгээ	хүн	6	400.000	2.400.000
Нийт дүн					2.400.000